

2008.01.31

Дугаар09

“Нийслэл даатгал” ХХК-ийн ердийн даатгалын
зарим хэлбэрийн тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, 70.1.1 дэх заалт болон “Нийслэл даатгал” ХХК-иас 2008 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр 01/08 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хорооны 2007 оны 7 дугаар тогтоолоор “Нийслэл даатгал” ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон даатгалын хэлбэрүүдээс дараах даатгалын хэлбэрүүдийг хасч хүчингүй болгосугай.

- 1/Хөдөлмөрийн чадвар алдалтын;
- 2/Бараа материалын;
- 3/Газрын тосны бүтээгдэхүүний;
- 4/Ажил олгогчийн хариуцлагын.

2.Тусгай зөвшөөрлөөр олгогдсоноос бусад даатгалын үйл ажиллагаа эрхэлж болохгүйг “Нийслэл даатгал” ХХК /З.Балдандугар/-д анхааруулсугай.

3.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ